

Ховд аймгийн төв.

- Би нэгэнт доор Ховд нутгынхаа талаар бичээд эхэлчихсэн болохоор, арай л дутуу юм шиг санагдаад нутгынхаа талаар дахин юм нэмж бичмээр санагдаад байна л даа! Ингээд би хvvхэд насаа онгороосон Ховд аймгийн товийн талаар бичье. Хvvхэд насаа онгороосон болохоор аймгийн тов маань миний хувьд хvvхэд насны гэнэн цайлган тосоолол болоод дурсамжаар дvvрэн байдаг юм. Манай аймаг баруун аймгууд дундаа ер нь гайгвй томдоо ордог - тийм ч болохоор баруун бvсийн тов гэсэн сайхан гуншинтай. Алтайн нурууны салбарууд дундаас урсах гол горхи болоод булаг шандны ус, зуны цагт монх цаст суваргуудын цас мосноос хайлж урссан ус, холын замдаа нийлэн нийлсээр Ховд аймгийн товийн хойхно талаар урсах тунгалаг Буянт гол маань болж урсдаг билээ. Буянт гол аймгийн тов хврэхийн наахна талд хоёр салаад, аймгийн товоос онгороод нэлээн доор эргээд нийлдэг. Харин тэгж салж урсахдаа хоорондоо 1000метр орчим нэлээн урт зайд урсах богоод, нутгийн бидний нэрлэж заншиснаар аймгийн тов талаасаа "Бага гол" ба "Их гол" гэсэн нэрvvдтэй 2 гол болж урсдаг. За ингээд Ховдчууд маань зуны цагт гэр бариад Буянт голынхоо эрэг дагаад лагерт гарна аа. Лагervvд дундаа бас газрын байрлалаасаа хамаараад оорийн гэсэн нэртэй - намайг бага байхад манайхан "Кино театр" ийн лагерт гардаг байлаа. Манай аймаг бас арвин тvvхийн эх болсон газар билээ. Ховд аймаг байгуулагдаад их удсан аймаг. Тэртээ дээр вед Хятадууд их олон байсан болохоор, Хятадуудаас л сурсан юм шиг байгаам Ховдчууд хvнсний ногоог vнэндээ л тасархай тарина.

- Ховдчууд бидний "Чандмань Эрдэнэ" болсон энэ сайхан Буянт голоороо ундаалуулж, Ховдчууд маань аймгийн товоосоо доошоо нэлээд зайтай Буянт голоо дагаад ногоо тарицгаана. Манай нутгынхан манжин байвал махаар яахав гэж ярицгаадаг нь оргвй vг биш юм. Учир нь манай Ховдчуудын тарьсан хvнсний ногоо - ээддээ мон ч сайхан час хийсэн сайхан амттай даа. Намрын цагт мон ч сайхансан - манай нутгынхан намрын цагт гурил хоолондоо бараг л оролцуулахгвй, энэ доор нутгын нэг хvний vлдээсэн коммент шиг "Ургацын далай" нэртэй торол бvрийн хvнсний ногоо, мах оролцсон - ёстой ногоо "Дээд уруулдаа хvргэмгвй, Дэргэдэх хvндээ огомгвй" гэдэг шиг л сайхан хоол хийж иднэ. Ногоо их сайхан боломжийн хямдхан ямар ч байсан оорсдийгоо чолоотэй хангана. Мон хэд хэдэн шуудайгаар нь томс, манжин, лууван гээд л хvнсний ногоонууд дарж аваад оволжингоо иднэ. За тэгээд алдарт Шийгуа, Тингуагаа юу гэж мартахаа - нутгын Шийгуай, Тингуа мон ч сайхан амттай даа - намрын цагт их хямдарна. Бага байхад ч ээддээ шуудай шуудайгаар нь авж ирж гэртээ тавьчихаад л идэж гардаг байлаа. Би аав оросоос авж ирсэн нэг хоорхон дугуйтай, шийгуа дуусангуут ээжийг найрч хэдэн тогрог аваад, шуудайгаа ардаа даруулчихаад л ногоо "Амар хуур" кинон дээр гардаг Соном шиг шийгуа авах гээд захруу жийх шиг болдог байж билээ! хэхэ Их амттай болохоор уйдна залхана гэж бараг байхгвй. Нутгаасаа оор газар тийм амттай Шийгуа, Тингуа идээгвй шиг санаж байна. За ингээд аймгийн товийн хvн мал, ургамал амьтан, эдгээр бvх зvйлийг

ундаалдаг энэ сайхан Буянт голоо Ховдчууд бид магтан дуулахаас оор яахав! Би Зангад гуайн дуулсан "Тунгалаг буянт" дуунд их дуртай. Ер нь хааяа нэг сайхан дуулчихад бас сэтгэл сэргээд явчихаж байх жишээтэй.

- Монголд байдаг бvх vндэстэн ястанаас хоёрыг нь эс тооцвол vлдсэн бvх vндэстэн ястанууд, хамгийн олон 18н сумтай Ховд аймгийн сумуудыг хувааж нутаглацгаана. Оороороо нэг жишээ татахад Дуут, Монх-Хайрхан гэсэн 2 сумууд бол Урианхайчууд болоод Хасар ахын нутаг байх жишээтэй. Аймгийн товоос дээшээгээ, 20 иод км шахам vргэлжилдэг урт сайхан тал байдаг. Тэр тал дунд авж ирээд тавьчихсан юм шиг ончин ганц "Баатар-Хайрхан" нэртэй уултай. Би хvvxэд байхдаа бас Оросын Украин дугуйтай байлаа. Энэ дугуйгаараа би "Баатар-Хайрхан" уул орчихоод ирдэг байж билээ. Ээддээ зуны цагт ч мон ч сайхан шvв! Буянт голынхоо ширгэн дээр очоод хэвтэж байхад ч сайхан даа. Овлийн цагт гол холдохоор хvмvvc канкигаар их гулгана. Намайг канкигаар гулгаж чадах уу? гэх гэж байна уу! хэхэ. Миний ганц сураагvй юм байгаа юм. Хvvxэд байхдаа канкигаар гулгадаг баатар болж, нэг канки углаад 3 алхаад л тэрийж тархиараа савж унаснаас хойш дахиж холдоо тэр канки гэж юм углаагvй юм даг. Ховд аймаг маань товчхон бичихэд нэг иймэрхvв л нутагдаа!

Мөнгөн давалгаа хаялсан Мөрөн голын минь урсгалтай Мөнх цастай Алтайн суваргаас Мяралзан урсдаг нь бахдалтай Хэдэн зуун уулсын чанадаас Хэрэн урсдаг Буянт минь Асралт ээжийн минь сvв шиг Ариун тунгалаг рашаан юм Улиас бургас шуугин ганхсан Уудам шаргал хөндийн дундуур Үндэстэн ястануудын бахдал болсон Үзэсгэлэнт Буянт минь урсдаг аа.